

## СИНЬЗЯНЫ ТҮҮХИЙН АСУУДАЛД

Л.Бэгэжав (Ph.D)

Синьзян-Уйгурын автономит район нь БНХАУ-ын баруун хойт хэсэгт орших хамгийн том район нь. Тус район 1 сая 646 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай бөгөөд энэ нь Хятадын газар нутгийн 17%-ийг эзлэнэ. Ази, Европын эх газрын төв дунд орших Синьзяны газар нутаг нь гурван Франц, дөрвөн Япон, зургаан Англи улсынх шиг буюу Англи, Франц, Герман, Голланд, Бельги, Дани, Япон гэсэн 8 улсын нутаг дэвсгэрийг нийлүүлсэн шиг өргөн уудам юм.

Далайгаас хол, дөрвөн талаараа уулсаар хүрээлэгдсэн, хур бороо багатай, хуурай салхитай Синьзян нь зүүн хойгуураа Монгол, хойгуураа ОХУ, баруун хойт, баруугаараа Казахстан, Киргизстан, Тажикстан улсуудтай, баруун өмнүүрээ Афганистан, Пакистан, Энэтхэг гэсэн 8 улстай 5700 км газраар хиллэдэг. Алтайн нуруу, Тэнгэр уул, Куньлун уул гэсэн гурван их уулс, Зүүнгар, Таримын Хотгор гэсэн хоёр их талын дундуур 721 гол мөрөн урсдаг. Үүнээс Иртыш мөрөн Хойт мөсөн далайд цутгадаг Хятадын цорын ганц гол юм. Тэнгэр уул бол Синьзяны бэлгэ тэмдэг бөгөөд Тэнгэр уулаас өмнөхийг өмнөд Синьзян, хойшхийг хойт Синьзян гэх ба Хами, Турфаны хотгорыг зүүн Синьзян гэдэг.

Жилдээ нарны туяа хамгийн их тусдаг газар учраас ургамал жимс ургахад нэн тохиромжтой. Тиймээс ч Синьзян “гуа жимсний орон” гэж алдаршсан билээ. Байгалийн бэлчээр Синьзяны газар нутгийн 30%-ийг эзлэх ба Хятаддаа хоёрдахь том мал аж ахуйн район юм.

Байгалийн асар их баялагтай ялангуяа нефть, байгалийн хийн маш их нөөцтэй. Хаана л бол хаана нүүрсний орд газартай урьдчилан төлөвлөсөнөөр нүүрсний нөөцөөрөө Шаньси мужаас давж, Хятадад 1-р байранд орж байна. Синьзяны нүүрсний уурхай бүх Европыг 60 жил хангаж чадах юм гэж геологчид үздэг. Алт, мөнгө, зэс болоод бусад байгалийн үнэт баялагаараа хол ойрдоо зартай газар юм. Иймээс ч түүхийн бүхий л үеийн туршдаа олон овог аймаг, улс гүрний тэмцлийн талбар болсоор ирсэн нутаг билээ.

Одоогоос нэг тэрбум жилийн өмнө өнөөгийн Синьзяны нутаг их далай байжээ. Хожим нь аажмаар 60-70 сая жилийн өмнө өнөөгийн байдал төрх нь бий болжээ. Синьзяны нутаг дэвсгэрээс шинэ чулуун зэвсгийн олдвор ихээхэн олддог байна.

Археологчидийн материал, сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр, шинэ чулуун зэвсгийн үед өнөөгийн Синьзян, төв Хятад, Монголын тал нутаг

\*. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

цэцэглэн хөгжсөн соёлтой, эдийн засаг худалдааны их хөлийн газар байжээ. Өнөөгийн Синьзяны түүх дэлхийд алдартай “торгоны зам”-тай нягт холбоотой. Торгоны зам нь Синьзяны түүхийн бүхий л үеийн мандал, бууралтанд нөлөөлсөн юм. Эртний Хятад, Энэтхэг, Перс, Монгол, Арабын соёл ба эртний Грек, Ромын соёлын хэлхээ холбоо, аж ахуйн эрэлт хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэж, дорно, өрнийн ард түмний соёл иргэншлийг холбоход түүхэн үүрэг гүйцэтгэсэн олон улсын их зам харилцаа байлаа. Хятадын эртний нийслэл Чананьгаас эх авч (одоогийн Сиань) баруун зүгт Газрын Дундад тэнгисийн зүүн эрэг хүрч байсан торгоны замын хагас нь өнөөгийн Синьзяний нутгаар дайрч байв. Иймээс Европ, Азийн эх газрын төвд орших Синьзян нь эртнээс эдүгээ хүртэл дорно өрнийг холбох гүүр болж, түүхэн их үйл явдал, олон төр улсын үүсэл, цэцэглэл, үхэл мөхлийн талбар болж байсан юм. Одоогийн Синьзяны нутаг дэвсгэрт оршин суугаа ард түмнүүдийн эртний болоод дундад зууны бүхий л түүх их тэмцлээр дүүрэн байлаа. Энд нэг овог аймаг нөгөө нэгнийгээ устгаж, гадны улсууд эзлэн авч, төр улс, соёл иргэншлийн голомт үүсч, мөхөж, бие даасан өвөрмөц соёл, ахуй амьдрал бий болж байлаа. Хоёр мянган жилийн тэртээгээс Хятадын түүх сударт энэ газрыг Си Юй буюу “баруун хязгаар” гэж нэрлэж иржээ.

Үүнээс өмнө Хятадын эзэмшил энэ газар хүрээгүй байв. Бүр МЭӨ II мянган жилийн үеэс Дундад Ази Дундад Дорнодын өргөн уудам энэ нутагт иран хэлтэн сак аймгийнхан анх суурьшсан гэдэг нь одоогоор мэдэгдэж буй түүх билээ. Сакчууд Дундад Ази, Афганистан, Хойт Энэтхэгийн угсаатан бүрэлдэн бий болоход чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хэдэн зуун зууны турш нүүдэлчин овгийнхон уусан нэгдэх, шинэ угсаа аймаг бий болох процесс үргэлжилжээ.

МЭӨ I мянган жилийн үеэс Тэнгэр уулын ар өвөрөөр иран-түрэг, монгол угсааны маш олон овог аймаг оршин сууж байсан бөгөөд тэдний аж ахуйн түвшин адилгүй ч ихэнхэд нь эцгийн эрхт ёс ноёрхож байв. Энэ үеэс Төв Азийн нутагт томоохон аймгууд нэгдэж, төр улс байгуулагдаж байсаны нэлээд хүчирхэг нь Хүннү аймаг байлаа.

Баруун Хань улсын үед (МЭӨ 209-МЭ 9). Өмнөд Синьзянд хэдэн арван хэрэм улс байсан ба умарт Синьзянд усун, юеши зэрэг нүүдэлчин аймаг ноёрхож байжээ. Монголын тал нутгийн Хүннү нар баруун хязгаарт тасралтгүй довтолж, эндэхийн олон жижиг улсыг авах гэсэн Хань улсын бодлогыг ямагт таслан зогсоож байжээ. Хань улсын бодлогыг Түрэгийн Билгэ хаан “Хятад бол элдэв өнгийн дүр үзүүлэхдээ гаргуун, яруу сайхан үг хэлж, түүгээрээ дамжуулан сэтгэлд нь таарахаар бэлэг сэлтээр дамжуулан алс хэтийн бодлогоор муу аргыг хэрэглэж, маш ухаалаг хүмүүс толгойг нь эргүүлсэний эцэст найз нөхөд, ах дүү, хөгшин залуу бүгдийг хооронд нь яс хаяж бутаргаж, алж хядан цус урсгах замаар аливаа орныг доройтуулан унагана. Түрэгүүд хятадуудаас хичнээн аврал тусламж ирсэн ч тэдний хувиршгүй улс төрийн бодлого түрэгүүдийг газрын хөрснөөс

үндсээр нь үгүй болгох болно. Энэ бол гарцаагүй үнэн гэж хэлсэн байдаг. Тэрээр энэ ирээдүйн Лүндэн адил зарлигаа 2000 гаруй жилийн тэртээ хэлжээ.

МЭӨ 177-176 онд Хүннүгийн Модун Шанью хаан баруун хязгаарт орж эзлэн авахад юеши нар (одоогийн афган) баруунш дугааж, усун нар дагаар орсоноор Тэнгэр уулын ар тал монголчуудын малын бэлчээр болсон байна. Тэд мөн өмнөд Синьзянд довтолж олон хэрэм улсыг хялбарханаар буулган авч байв. Ийнхүү анх энэ газар монголчууд ноёрхож байв.

МЭӨ 104 онд Хань улсын Уди хаан (МЭӨ 140-87) 60 мянган цэргээр баруун хязгаарын Давань улсыг (одоогийн Узбекистаны Ферганы хөндий) эзлэн авчээ. Энэ үеэс Хань улс Хүннү улстай тасралтгүй харилцан байддаж, Хүннү нарыг сулруулан МЭӨ 60 онд баруун хязгаарыг эзэмшилдээ авч, энэ үеэс өрнийн газар нутаг гэж тооцох болсон юм. Гэвч энэ байдлаа олон удаа олон зуун жилээр алдаж байсан нь дэлхий нийтийн эрт, дундад түүхийн нэг адил билээ.

Сүүлийн хоёр мянган жилийн туршид Синьзянд Хятад ноёрхолоо тогтоосон хугацаа нь 425 жил орчим юм гэж хятад судлаачид тооцоолсон байна. Чухамдаа бодитойгоор цэрэг улс төрийн ноёрхолоо Хятад улс баруун хязгаарт тогтоосон нь Манж Чин улсын үе үед юм гэж Зөвлөлтийн эрдэмтэн Б.П. Гуревич үзэж байна.

“Баруун хязгаарт” МЭ III-IV зуунд Жужань (Нирун) улс хяналтаа тогтоож байв. МЭ VI зуунд Төв Азийн уудам дэлгэр нутагт Түрэгийн хаант улс хүчирхэгжин мандсан боловч Дорнод Түрэг, баруун Түрэг гэж хоёр улс болон задарсан юм.

Долоон мөрний газар нийслэлд сууж байсан баруун түрэг улсыг МЭ VII зуунд Хятадын Тан улс (618-907) эзэлсэн юм. Түрэгийн бичиг үсгийн дурсгалуудад Төв Азийн түрэгчүүд Хятадын эзэнт улстай олон зуун жил тэмцэлдэж байсаныг тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй. Түрэгийн Тоньюкук хаанд зориулан босгосон хөшөөн дээр Хятадын эсрэг Эльтерим хаан “арван долоо удаа байлдаж явсан билээ” гэж бичжээ.

Түрэгчүүдийн шаргуу эсэргүүцэл, төвдийн нэр хүнд өссөн явдал, Арабчууд Дунд Ази, өмнөд Казахстанд довтолж орсон нь Тан улсын довтолгоог таслан зогсооход хүргэжээ.

IX зууны дунд үеэр Орхон, Сэлэнгийн сав газраас үлэмжхэн тооны уйгарууд энд нүүдэллэн иржээ. Уйгарчууд бол өнөөгийн Синьзяны голдох үндэстний нэг билээ. Гэвч өнөөгийн уйгар үндэстэн XV-XVI зууны үед бүрэлдэн бий болсон юм. Уйгарчуудын уг удам бол Монголын тал нутгийн Хуйхэ буюу хойхуур нар юм. (Өнөөгийн Монголын хотгойд) Эдний уг гарал нь Диньлинь юм. Диньлинь нар МЭӨ III зуунд Монголын тал нутаг, өмнөд Сибирээр нутаглаж байсан овог аймаг юм. Тэд тал нутгийн хүннү, сяньби, жужан нарт боолчлогдон уулархаг ой модтой газар буюу Монголын хойт хэсэгт ан агнаж, мал маллаж амьдарч байв. МЭ IV зуунаас

хойш тэднийг тизэ лэй, (тэрэг татагч) буюу гаочэ (өндөр тэрэгт) гэж бас нэрлэх болжээ. Тэд овгийн байгуулалаар амьдарч байв.

V зууны дунд үеэс хойш Зүүнгарын хотгорын зүүн хэсэгт ашинаши нараар цөм болгосон тизэлэй аймаг гарч ирсэнийг Түзю (гэнэт манарах) буюу түрэг гэж нэрлэх болжээ. Тэд аажмаар хүчирхэгжин Түрэгийн хаант улсыг 552 онд байгуулсан. Түрэг улсыг 745 онд Тан улс довтлоход боолын дарлалд байсан Хуйхэ ба уйгарчууд босон тэмцэж говийн хойгуур уйгарын хаант улс байгуулсан юм. Олон зууны турш аажмаар ингэж уйгур үндэс бүрэлдэж эхэлсэн юм. 840 онд уйгур улс гадна, дотнын хүчин зүйлээс унаж уйгурчууд язгууртанаа дагаж 4 зүгт тарсан байна. Нэг хэсэг 100 мянган хүн өмнө зүг Иньшан уулын өмнүүр цагаан хэрмийн хавиар нутаглаж байгаад ихэнхи нь сүйрч устжээ. Нөгөө нэг хэсэг төв Хятад руу явж хятадад уусч, бас нэг хэсэг нь баруун зүг явж Куньлунь уулын Чу голын хавьд, бас нэг хэсэг нь Зүүнгарын хотгорт хүрч өөр бусад үндэс ястантай нийлжээ. Сүүлчийн хоёр хэсэг уйгурчууд Турфаны уйгар улс, Карахан улсыг байгуулсан байна.

943 онд Караханы улсын хаан лалын шашинд орж, аажмаар араб үсэг авч түрэг хэлтэй болжээ. Турфаны уйгур улс нь уйгур бичиг хэрэглэж буддын шашин шүтэж байв. Энэ үед уйгурын Кашгар, Хотон, Яркенд зэрэг хотууд Дундад Азийн худалдаа, соёлын төв болж байв.

XIII зуунд энэ хоёр улс аль аль нь мөхөж энэ нутаг бүхэлдээ Цагаадайн улсын харъяанд орсон юм. Эндэхийн монгол угсааныхан аажмаар түрэгжсэн байна. Монголын хаад шашин шүтэх явдлыг чөлөөтэй тавьсаны улмаас мусульман шашин, буддын шашны хооронд ямагт зөрчил тэмцэл гарч байлаа. 1370 онд Цагаадайн улс задарч, хэд хэдэн жижиг улсууд гарсан юм. Аажимдаа мусульман шашныхан дийлж, улс төр, эдийн засаг, соёл шашны талаар нэгтгэн захирах болсноор орчин үеийн уйгур үндэстэн бүрэлдэн бий болжээ.

Чингис хаан 1218 онд Баруун зүг дайлаар мордож өнөөгийн Синьзян ба Дундад Азийг бүхэлд нь Монголын эзэнт гүрний мэдэлд оруулсан юм. Чингисийн дараа хүүхдүүд нь энэ нутгийг хуваан авч захирч байлаа. 1271-1368 онд Синьзян Юань гүрний буюу мөн л Монголын эрхшээлд байсан юм. Энэ үед торгоны их зам дагуу газар сайгүй Монгол өртөө байгуулагджээ.

XVI зууны эхний хагасаас Цагаадайн улс задарч, тус тусдаа улс болон оршиж байв. XVI зууны эхээр Цагаадайн удмынхан задарсан энэ улсуудыг нэгтгэж Кашгарын хаант улс гэж байгуулж бараг 100 орчим жил оршин тогтноод 1678 онд мөхсөн юм. Кашгарын улсын хойт захад Зүүнгар аймаг оршиж байв. Зүүнгар бол Монголын 4 их ойрадын нэг юм. Ойрадууд Монголын баруун хойт хэсэг ба Енисей мөрний эхээс ирж XVI зууны сүүлч XV зууны эхээр өнөөгийн Синьзяны зүүн хойт хэсэг Алтайн хавьд ирж суурьшин хойт Синьзян дахь Цагаадайн удмынхантай тасралтгүй

тэмцэж байлаа. ХҮИ зууны эхээр Ойрад 4 аймгийн дундаас хамгийн хүчирхэг болох Зүүнгар аймаг хойт Синьзяныг дайран эзэлж, Зүүнгарын хаант улсыг 1678 онд байгуулав. Улмаар өмнөд Синьзяныг эзлэн хүчирхэгжижээ. Манж Чин улсад энэ хязгаар эзлэгдэх хүртэл Монголын язгууртнууд 500 гаруй жил өнөөгийн Синьзяныг эзэгнэн суусан юм.

Баруун Монголын ойрад буюу Зүүнгарын улсыг манжийн Цянь Лун (тэнгэр тэтгэгч) хаан 1755-1759 онд олон удаагийн дайны дараа хүч түрэмгийлэн эзэлсэн юм. Энэ тухай Хятадын түүхэнд ингэж бичжээ. “Хүн амыг нь бараг толгой дараалан, хайр найргүй устгаж байж сая л Зүүнгарыг дийллээ. Зүүнгар улс цэцэглэлтийнхээ ид үед 200 мянга гаруй өрх айл буюу 600 мянга гаруй хүн амтай байжээ. Зүүнгарыг байлдан дагуулсны дараа хүн амын аравны гурав нь Чин улсын цэрэгт алагдаж, аравны дөрөв нь цэцэг өвчнөөр нас барж, үлдсэн хэсэг нь Оросын нутаг дэвсгэрт казакууд руу аргагүй эрхэнд зугатав”<sup>8</sup> гэжээ. Манж нар хүн амыг бараг толгой дараалан хядаж, олон хот суурин, газар тариалангийн нутгийг эвдэн сүйтгэсэн байна. Олон түүхчдийн үзэж байгаагаар энэ дайнд нэг сая гаруй хүн алагджээ.<sup>9</sup>

Хэдийгээр манж нар ийн харгисласан боловч манжийн эсрэг томоохон бослого хөдөлгөөн 1765, 1816, 1825-1828, 1830, 1847, 1856, 1857 онуудад тасралтгүй гарч байв. Эдгээр бослого нь урсгалаараа, зохион байгуулалтгүй өрнөж байв. Харин XIX зууны 60-аад онд манжийн эсрэг хөдөлгөөн ихэд идэвхижиж Кашгар, Зүүнгарын нутаг дээр уйгаруудын ба дунгануудын гэсэн бие даасан улс бий болов. Уйгарын улсад багтаж байсан Куча, Хотон, Кашгарын хант улсын үндсэн дээр 1867 онд нэгдсэн Йэттишар улс байгуулагдсан байна.<sup>10</sup> Энэ улсын удирдагч нь цэргийн дарга Якуб-бек байсан бөгөөд тэрээр Дунганы улс болох Урумчийн хант улсыг 1869-1870 онд эзлэн авч нэгтгэснээр Уйгарын ард түмэн тусгаар тогтнолоо олжээ. Гэвч энэ нь 11 жилийн турш оршин тогтноод манж-хятадын цэрэгт цохигдон мөхсөн байна.

Манжийн Засгийн газар ийнхүү Йэттишарын улсыг унагасны дараа 1884 онд “баруун хязгаарыг” муж болгон өөрчилж шинэ хязгаар гэсэн утгаар Синьзян гэж нэрлэв. Энэ муж нь хятадын бусад мужтай нэгэн адил болж, цаашид дотоод бүх мужтай харилцаа нь гүнзгийрэв. Синьзяны засаг захиргааны төвийг Или-гээс Урумчид шилжүүлэв. Өрнөдийн түүхчид Синьзяныг Дорнод Түрэгстан гэдэг бөгөөд тэр нь угаасаа бие даасан улс байсан, манж нар эзэлсний хойно тэдний колони улс болсон. Иймээс манж нар шинэ эзэлсэн газраа Синьзян гэж нэрлэсэн гэж үздэг билээ. (Турк улсаас ялгах үүднээс ингэж нэрлэсэн ба энэ нь турк гэдэг нь Түрэг, Стан гэдэг нь улс гэсэн үг)

Манж нар байлдан эзэлсэн газар нутагтаа цэргийн суурин гэгчийг байгуулж, олон зуун цэргүүдийг суурьшуулан суулгаж байв. Манж-хятадын цэргийн эрхтэн нар Синьзянд колонийн харгис дэглэм тогтоож,

орон нутгийн засаг захиргааны бүхий л үйл ажиллагааг хятад түшмэдийн аппаратад хянаж байв.

Манж-хятадын цэрэг, феодалын эрх баригчид Синьзяны ард түмнийг олон аргаар мөлжиж байлаа. Нутгийн хүн ам хэмжээгүй их алба төлж, хятадын цэрэг түшмэдийг тэтгэн тэжээж байв. Тухайлбал, Синьзяны тариачин нэг бүр хятадын 3 цэргийг тэжээх албан журмын үүрэгтэй байв. Өөрийнхөө газар нутгаас хөөгдсөн тариачид газрын шинэ эзэн хятадуудаас газар түрээслэн авахад хүрч байсан бөгөөд хятадын мөнгө хүүлэгч худалдаачид булаан эзлэгдсэн газар луу нутгийн хүн амыг цөлбөн тонохоор улайран тэмүүлж байлаа. Хятад түшмэд бүр эзэмшсэн газар дээрээ нутгийн 700-100 тариачинг ажиллуулдаг байжээ. Нутгийн хүн ам, барилга байшин барих, зам гүүр тавих зэрэг хүнд хэцүү албанд дайчлагдан ажиллаж, өчүүхэн бага газраа өр төлөөсөнд өгч, идэх юмгүй байнгын өртөн болох нь олонтаа байв.

Манжийн түрэмгийллийн үед Синьзян эдийн засгийн нэн хоцрогдмол колонийн район болсон ба хүн амын эрхлэх гол аж ахуй нь урьдын адил газар тариалан, мал аж ахуй, гар урлал байв.

Хятадууд тэр үед нутгийн ард түмнийг хүчээр уусган, хятадчилах бодлого явуулж, лалын сүм хийдийн дэргэдэх сургуулийг хааж, мусальманы зан заншлыг хориглон, уйгар, дунганчуудыг хятад бичиг үсэгт сургах ажлыг хийж байжээ.

Хэдийгээр ингэж ардын бослогыг харгислан дарж байсан боловч Синьзяны ард түмний чөлөөлөх тэмцлийг эцэс болгож чадаагүй юм. 1911-1912 онд Манж Чин улсын ноёрхлыг түлхэн унгасан Хятадын хөрөнгөтний хувьсгалын нөлөөгөөр (Синьхайн хувьсгал) Синьзянд эрх чөлөөний хөдөлгөөн улам өргөн далайцтай өрнөх болов.

1917 онд Орос оронд гарсан Октябрийн хувьсгалын нөлөөгөөр Дундад Ази, Казахстан дахь феодалын байгууллыг устгаж, Бүгд Найрамдах улсын хэлбэрээр узбек, тажик, киргиз, хасгийн ард түмэн өөрсдийн улсыг байгуулсан нь синьзяны ард түмэнд ихэд нөлөө үзүүлж, тэнд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн шинээр өрнөн хөгжив.

1931-1933 онд Ходжа Ниязийн удирдлагаар томоохон бослого Синьзянд гарсны үрээр 1933 оны 7-р сарын 10-нд Хятадын Гоминьданы засаглал унаж, Дорнод Түрэгстаны Бүгд Найрамдах улсыг тунхаглав. Бүгд Найрамдах улсын засгийн газар империализмтай тэмцэх, ЗХУ-тай найрамдалт харилцаатай байх, синьзянд 120 мянга гаруй хүнийг баривчилж 80 мянгыг нь зэрлэгээр хөнөөжээ.<sup>11</sup> Синьзяны засаг захиргааны төв Урумч хот шоронгийн хот болжээ. 100 мянга оршин суугчидтай байсан энэ хотод 30 шорон байсан ба тэдгээрт янз бүрийн үндэстэн ястны 12 мянга гаруй хүн амь насаа алджээ.<sup>12</sup>

1933-1944 онд Синьзян мужийн захирагч байсан Шэн Шицай ард түмний бослого тэмцлээс болгоомжилж, ардчилсан хүчний шахалт, тэр үеийн ЗХУ-ын Хятад улстай харилцаж байсан улс төрийн бодлогын

нөлөөгөөр эхэн үедээ ард түмний тэгш эрхийн төлөө тэмцэгчдийн талд байсан юм. Тухайн үед Синьзян нь ЗХУ-тай хэвийн харилцаатай байж, улс төр, эдийн засаг, соёлын харилцааг өргөтгөх арга хэмжээ авч байжээ.

Тэр жилүүдэд Зөвлөлтийн иргэд Синьзянд төрийн өндөр үүрэг гүйцэтгэж байв. Тэд синьзянтай худалдаа хийж зөвлөлтийн мэргэжилтэн нар аж үйлдвэрийн газар барих, геологи уул уурхайн хайгуул хийх, хөдөө аж ахуйг техникээр хангах зэрэгт туслалцаа үзүүлж байв.<sup>13</sup>

Гэвч 1942 оны дунд үеэс Шэн Шицай байр сууриа огцом өөрчилж, зөвлөлтийн эсрэг үзэл баримталж, улмаар ЗХУ-тай эдийн засаг, худалдааны харилцаагаа тасалсан юм. Тэрбээр Гитлерчуудийн түр зуурын амжилтыг ашиглаж Японтой холбоо тогтоох, улмаар “ялагдашгүй” Германтай харилцах суурь тавих гэж оролджээ. Түүний ивээлээр синьзянд японы тагнуулын сүлжээ өргөжиж, хүн амыг олноор баривчлах, буудан хороож харгислаж эхэлсэн юм. Ялангуяа Гоминьданы хятадын гадаад, дотоод бодлогыг шүүмжлэх гэж оролдсон уйгар, казак, коммунистууд энэ харгислалд олноор өртжээ.

1943 оны 4 дүгээр сард Чан Кайшигийн цэрэг Синьзянд цөмрөн орж, хятадын коммунистуудын эсрэг залхаан цээрлүүлэлт хийв. Аксу, Кашгар, Яркенд, Хотан зэрэг хотуудад фашист бүлэглэлүүд байгуулагдаж “бүх дэлхийн коммунистууд”-ын эсрэг тэмцэлд япон, германтай хамтран тэмцэхийг илэрхий уриалж байв.

Урумч хотод АНУ-ын Ерөнхий консулын газар байгуулагдсан бөгөөд түүнийг ЗХУ-ын эсрэг хорлон сүйтгэх үйл ажиллагаанд мэргэжсэн тагнуулч Клабб удирдаж байв. Хами, Урумч, Кулджа, Кашгар хотуудад цэргийн бааз, нисэх онгоцны буудал барьж, ЗХУ-д тагнан турших, хорлон сүйтгэх ажиллагаа гүйцэтгэх хүмүүсийг шургалуулах болов. Синьзян дахь Зөвлөлтийн консулын газар хаагдаж зөвлөлтийн мэргэжилтнүүдийг эх оронд нь буцаав.

Энэ үед ч гэсэн Гоминьданы ноёрхлын эсрэг ард түмний эсэргүүцэл тэмцэл өрнөсөөр байв. ЗХУ дэлхийн хоёрдугаар дайны явцад үндсэн эргэлт гаргасны үрээр 1944 оны намар Синьзяны үндэстний эрх чөлөөний хүчирхэг өрнөлтөд таатай нөхцөл бүрэлдэн бий болов.

1944-1946 онд гарсан синьзяны ард түмний томоохон зэвсэгт бослогын явцад, Синьзяны Или, Тарвагатай, Алтайн 3 тойрог гоминьданы дарлалаас чөлөөлөгдснөөр, 1944 оны 11 дүгээр сарын 15-нд эдгээр чөлөөлөгдсөн нутаг дэвсгэр дээр дахин Дорнод Түрэгстаны Туркмен Бүгд Найрамдах Улс гэж байгуулагдсаныг зарлав.

Дорнод Түрэгстаны Засгийн газар босогчдын отрядыг байнгын цэргийн анги болгон эмхлэн зохион байгуулж, “Синьзян” гэдэг нэрийг өөрчлөв. Гоминьданы харгис дэглэмийг устгах, ардчилсан өөрчлөлт хийх, ЗХУ-тай найрамдалт харилцааг хөгжүүлэх, эдийн засаг, соёл гэгээрлийг хөгжүүлэх, хүн амын, амьдралын түвшинг дээшлүүлэх, үндэстний цэрэг

арми байгуулах зэрэг арга хэмжээг тусгасан 9 зүйл бүхий ДТБНУ-ын программыг батлан гаргажээ.

Синьзян дахь ноёрхлоо бүрмөсөн алдчихгүйн тулд Чан Кайши 1945 оны 9 дүгээр сард ДТБНУ-ын Засгийн газрыг хүлээн зөвшөөрөх, синьзянд “орон нутгийн автономи эрх” олгохоо арга буюу зарлажээ.

БНУ-ын удирдагчид Дэлхийн хоёрдугаар дайны дараах олон улсын болон хятадын дотоод улс төрийн амьдралын өөрчлөлтийг харгалзан үзэж, ХКН-ын улс төрийн чиг шугамд нийцүүлэн Гоминьданыхантай хэлэлцээр хийхийг зөвшөөрсөн юм. Тэд хятадын хувьсгал ялсны дараа ХКН, марксист-ленинист зарчмыг удирдлага болгон үндэсний асуудлыг шийдвэрлэж, синьзяны ард түмэн БНМАУ маягийн биеэ даасан улс болох юм уу, эсвэл БНХАУ-ын бүрэлдэхүүнд ЗХУ-ынх шиг холбооны бүгд найрамдах улсын эрхтэй орно гэж итгэж байлаа.

1946 оны 6 дугаар сард Гоминьданыхантай энх тайвны хэлэлцээр байгуулж, хэлэлцээнд зааснаар ДТБНУ-ын Засгийн газар өөрийгөө тараасныг зарлав. Ингэснээр синьзянд 25 хүний бүрэлдэхүүнтэй эвслийн засгийн газар байгуулагдсан ба тэдгээрээс 15-г нь орон нутгийн хүн амын дундаас сонгох, үлдсэн 10-г нь хятадын төв засгийн газраас томилохоор тогтжээ. Синьзяны эвслийн засгийн газрын даргаар Жэн Жижун, орлогчоор Ахметжан Касами, Бурхан Шахиди нар томилогдсон байна.

Ардчилсан хүчнийхэн эвслийн засгийн газар байгуулагдсан явдлыг Синьзянд энх тайванч замаар ардчилсан өөрчлөлт хийхэд анхдагч алхам гэж үзэж байсан бол Гоминьданыхан үүнийг ардчилсан хөдөлгөөнийг хагалан бутаргах, олон түмнийг хуурахад чиглэсэн ов мэх гэж тайлбарлаж байв.

1946 оны 2 дугаар сараас эхлэн гоминьданы талынхан найрамдалын хэлэлцээрийг илтэд зөрчих болж, ардчилсан хүчний эсрэг дайран давшлах болов.

Ийм нөхцөлд Ахметжан Касами тэргүүтэй ДТБНУ-ын төлөөлөгчид 1947 оны 8 дугаар сарын 26-нд эвслийн засгийн газрын бүрэлдэхүүнээс гарч, чөлөөлөгдсөн 3 тойргийн районд буцаж очжээ.

1949 оны зун ХКН-ын удирдагчид синьзяны чөлөөлөгдсөн 3 тойргийн (Ил, Тавагатай, Алтай) удирдагчидтай холбоо тогтоож Хятадын Ардын улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн I чуулганд синьзяны ард түмний төлөөлөгчдийг оролцуулах болжээ. Синьзяны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд синьзяны ард түмний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн болох Ахметжан Касами, генерал Исках-бек, Абдукарим Аббасов, Далельхан нар оржээ. Тэд УТЗЗ-ийн чуулганы өмнө ХКН-ын удирдагчидтай уулзаж, марксист-ленинист зарчмын дагуу синьзяны өөртөө засах эрхийн тухай асуудлыг тавихаар төлөвлөж байжээ. Гэтэл төлөөлөгчдийн сууж явсан онгоц Бээжин орох замдаа маш учир битүүлэг шалтгаанаар сүйрчээ.



Ингээд УТЗЗ-ийн чуулганд оролцох Синьзяны шинэ төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Синьзяны эрх чөлөөний хөдөлгөөнд оролцож байгаагүй буюу урьд нь гоминьданы засгийн газарт өндөр албан тушаалд байсан хүмүүс орсон байна.

1949 оны 9 дүгээр сарны 21-30-нд Бээжинд болсон УТЗЗ-ийн анхдугаар чуулганаар БНХАУ-ыг тунхаглаж, Ардын төв Засгийн газрыг сонгожээ. Хятадын хувьсгалын ялалтыг синьзяны ард түмэн өөрийн үндэсний баяр мэт угтан, их найдвар итгэл тавьсан билээ. 1949 оны 10 дугаар сард синьзяны нутаг дэвсгэрт ХАЧА-ийн ангиуд орж, засгийн эрх мэдэл БНХАУ-ын төв засгийн газрын мэдэлд шилжжээ. Хятадын хувьсгал ялсны дараах эхний жилүүдэд синьзяны аж үйлдвэр, хөдөө аж ахуй, соёлын салбарт тодорхой амжилт гарсан юм.

Түүхийн шинэ үедээ орсон Синьзянд ЗХУ ихээхэн тусламж үзүүлж байлаа. ЗХУ-ын тусламжтайгаар Синьзянд үйлдвэрлэл, уул уурхай, нефть, төмөрлөг боловсруулалт, химийн болон бусад салбарууд шинээр бий болон хөгжжээ. Синьзянд боловсон хүчин бэлтгэх, хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, ном хэвлэх, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээр зөвлөлтийн олон тооны мэргэжилтэнгүүд тэнд ажиллаж байв.

Синьзяны олон үндэстний ард түмэн Зөвлөлтийн Дундад Азийн бүгд найрамдах улсууд, Казахстантай улам бүр холбоо тогтоож байлаа. Синьзяны залуучууд Алма-Ата, Ташкент болон Зөвлөлтийн бусад их дээд сургуульд олноор суралцах болов.

1950 оны 1 дүгээр сараас орон нутгийн засаг захиргааг шинэчлэн өөрчлөв. 1952 оны намраас газрын шинэтгэл хийж 1953 оны эцэс гэхэд дууслаа. Газрын эздийн 5230000 му газар, 70 мянга гаруй толгой мал, 40 мянган тариалангийн багаж, 200000 өрөө байшин хурааж ядуу тариачдад олгожээ. 1949-1953 онд Синьзяны малын тоо толгой 3610000-аар өсч, 15430000 болжээ.

1955 оны 9 дүгээр сард Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Байнгын хорооны шийдвэрээр Синьзян мужийг татан буулгаж Синьзян Уйгурын өөртөө засах орон болгохоор шийджээ. Мөн оны 10 дугаар сарын 1-нд СУАР албан ёсоор байгуулагдсаныг зарласнаар Синьзяны түүхийн бас нэг шинэ үе эхэлсэн юм.

## ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Янь Цэ. "Синьзян зунхэн" Бээжин. 1991. 285 дахь тал.
2. Мөн зохиол. 1-р тал.
3. Е.И. Сливанов. По западным районам КНР. М., 1986, 5-р тал.
4. Драмсалад хэвлэгддэг "Шижа" сэтгүүл (мэдэгдэхүүн), 1985, № 5.
5. Э.Пунцаг. Синьзян, өчигдөр, өнөөдөр "Хөдөлмөр" сонин. 1987.10. 04.
6. Хятад дахь хэрэг явдлын тухайд /1973-1976/. II дэвтэр УБ, 1979, 144-р тал
7. Б.П.Гуревич. "Великоханьский шовинизм и некоторые вопросы истории народов центральной Азии в XVII-XIX в" Вопросы истории. 1974, № 9.
8. С.Е.Маслов. Эртний Түрэгийн бичиг соёлын дурсгалууд, М., 1951, 69-р тал.
9. Хятадын түүхэн найруулал. Шэн Юэ редакторлов. М., 1959. 549-р тал.
10. Б.П.Гуревич. XVIII зууны II хагаст Манж Чин Улс Төв Азид цөмөрч орсон ба Орос улсын бодлого "Истории СССР" 1973, № 2  
Л.И.Думан. Завоевание Цинской империей Джунгарий и Восточного Туркестана. "Манжчурское владычество в Китае" М., 1966. 268-р тал.
11. А.Д.Иснев. Уйгурское государство Йэйтишар. М., 1981. 3-р тал.
12. Синьзян газети. 1951.5.3.
13. Национальный вопрос в Китае. М., 1971. 35-р тал.
14. В.И.Иваненко. Тропой памяти. М., 1968.17-р тал.
15. БНХАУ-ын Синьзян-Уйгурын Автономит район. УБ. 1984. 4,5-р тал.
16. БНХАУ-ын үндэсний районууд дахь Маогийнхны их гүрний бодлого. УБ., 1978. 48-р тал.
17. Янь Цэ. "Синьзян зунхэн" Бээжин 1991. 45 дахь тал.